



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/243

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 16 дугаар зарлиг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 2021 оны ТГ/520, ТГ/522 тоот албан бичгүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг яамны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал Д.Ганзориг нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т хариуцуулсугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1321100544

Батлан хамгаалахын сайдын 2021 оны  
09 дугаар сарын 29-ны өдрийн  
А/243 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2022 ОНЫ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: “Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр”-т батлан хамгаалах талаар тусгагдсан арга хэмжээг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагаатай уялдуулж, хэрэгжилтийг хангах, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хүрээнд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Бодлогын зорилтууд	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэгч			Хөрөнгийн эх үүсвэр /сая.төгрөг/
							Үндсэн	Хамтрагч	Оролцогч	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
<i>Нэг. Үндэсний болон гадаад бодлогын аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар:</i>										
Зорилт -1.1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалыг шинэчлэн батлуулах, “Монгол хүний аюулгүй байдал” хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	1.	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд батлан хамгаалах чиглэлээр тусгуулах саналын төслийг боловсруулах, холбогдох ажлын хэсэгтэй хамтран ажиллах	2021-2022 онд	Санал	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	ҮАБ-ын үзэл баримтлалд батлан хамгаалах чиглэлээр санал тусгагдана.	БХЯ-ны СБТГ	ЗХЖШ	ҮАБЗ-ийн ажлын алба	Төсөв шаардахгүй
	2.	Гадаад бодлогын үзэл баримтлалд батлан хамгаалахын чиглэлээр тусгагдах саналын төслийг боловсруулах	2021-2022 онд	Санал	Гадаад бодлогын үзэл баримтлал	Үзэл баримтлалд батлан хамгаалах чиглэлээр санал тусгагдана.	БХЯ-ны ГХАГ	ЗХЖШ, БХЯ-ны СБТГ	ҮАБЗ-ийн ажлын алба, ГХЯ	Төсөв шаардахгүй

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	3.	“Монгол хүний аюулгүй байдал” хөтөлбөрт батлан хамгаалах чиглэлээр тусгагдах саналын төсөл боловсруулах	2022 оны I улиралд	Санал	-	Хөтөлбөрт батлан хамгаалах чиглэлээр санал тусгагдана.	БХЯ-ны СБТГ	ЗХЖШ	БХЯ-ны бусад газар, хэлтэс	Төсөв шаардахгүй
	4.	“Монгол хүний аюулгүй байдал” арга хэмжээний хүрээнд хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	2022-2024 онд	Зохион байгуулсан сургалт, сурталчилгаа	Хүүхэд, залуучуудад эх, оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр	Хүүхэд, залуучуудад чиглэсэн “Дөл” тэмцээн, сургалт, сурталчил-гаа 2 удаа явагдана.	БХЯ-ны ТЗУГ	ЗХЖШ	Төрлийн цэргийн команд-лал	70,0 /улсын төсөв/
	5.	Хүн ам, удмын сангийн болон хүнсний аюулгүй байдлын талаар уг хөтөлбөрт санал боловсруулах	2022 оны I улиралд	Санал	-	Санал боловсруу-лагдана.	БХЯ-ны СБТГ	ЗХЖШ, БХЯ-ны бусад газар, хэлтэс	ҮАБЗ-ийн ажлын алба, ЦТЭ	Төсөв шаардахгүй
Зорилт -1.2. Тусгай хүчний болон Кибер аюулгүй байдлын цэрэг, Цэргийн тагнуулын байгууллагыг бэхжүүлэх, цэргийн цолны үнэлэмж, зохистой харьцааг бий болгох, цэргийн дүрэмт хувцасны зүй бус хэрэглээг хязгаарлах хууль эрх зүйн	6.	Тусгай хүчний цэрэг, Кибер аюулгүй байдлын цэрэг, Цэргийн тагнуулын байгууллагын төсвийг жил бүр Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороогоор хэлэлцүүлэн, тусгайлан шийдвэрлүүлж байх хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгох	2022-2024 онд	Хэрэгжил-тийн хувь	Зэвсэгт хүчний төсвийн багцад Тусгай хүчний болон Кибер аюулгүй байдлын цэрэг, Цэргийн тагнуул багтсан байна.	УИХ-ын Тусгай хяналтын дэд хороогоор төсвийг шийдвэр-лүүлж байх хууль, эрх зүйн зохицуулалт бий болно.	БХЯ, ЗХЖШ	ТХЦК, КАБЦК, ЦТГ	УИХ-ын Тусгай хяналтын дэд хороо	Төсөв шаардахгүй
	7.	Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Цэргийн тагнуулын байгууллагыг Зэвсэгт хүчний Жанжин штабын бүтцэд буцаан байгуулах	2021-2022 онд	Хэрэгжил-тийн хувь	Цэргийн тагнуулын байгууллага ТЕГ-т харьяалагдаж байна.	Цэргийн тагнуулын байгууллага ЗХЖШ-ын бүтцэд шилжинэ.	БХЯ	ЗХЖШ, ЦТГ	ТЕГ	Төсөв шаардахгүй

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
орчныг улам боловсронгуй болгох	8.	Цэргийн цолны үнэлэмж, зохистой харьцааг бий болгох, цэргийн дүрэмт хувцасны зүй бус хэрэглээг хязгаарлах зорилгоор цэргийн цол олгох, дүрэмт хувцасны хэрэглээг зохицуулсан эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэх	2021-2022 онд	Эрх зүйн баримт бичгүүд	“Цэргийн цол олгох журам”, “Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл”, “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”	“Цэргийн цол олгох журам”, “Дээд офицерын ангилал, цолны зэрэглэл”, “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм” шинэчлэгдэнэ.	Ажлын хэсэг	ЕТГ, БХЯ, ЗХЖШ, Төрийн цэргийн байгууллагууд	Хууль сахиулах байгууллагууд	Төсөв шаардахгүй
<b>Хоёр. Дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгох талаар:</b>										
Зорилт - 2.1. Улсын болон цэргийн дайчилгааны төлөвлөгөө, даалгаврыг шинэчлэх	9.	Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө /УДНТ/-г боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	2022 онд	Хэрэгжилтийн хувь	УДНТ боловсруулалтын шатанд 10 хувь	УДНТ-г батлуулсан байна.	БХЯ-ны СБТГ	ЗХЖШ	Яамд, Аймаг, нийслэлийн ЗДТГ	Төсөв шаардахгүй
	10.	Яамд, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөө, даалгаврын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	2023 онд	Хэрэгжилтийн хувь	Дайчилгааны даалгаврын төсөл 50 хувь	Дайчилгаа-ны төлөвлөгөө, даалгаврын төсөл батлагдана.	БХЯ-ны СБТГ	ЗХЖШ	Яамд, Аймаг, нийслэлийн ЗДТГ	Төсөв шаардахгүй
	11.	Дайчилгаа зарласан үед үүрэг зориулалтыг нь өөрчлөн цэргийн зориулалтаар ашиглах байгууллага, аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг батлуулах	2021 онд	Хэрэгжилтийн хувь	Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн жагсаалт 50 хувь	БайгууллагаААН-ийн жагсаалтыг гаргана.	БХЯ-ны СБТГ	ЗХЖШ	Яамд, Аймаг, нийслэлийн ЗДТГ	Төсөв шаардахгүй

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
<b>Гурав. Барилга-инженерийн цэргийг бэхжүүлэх, бүтээн байгуулалтад оролцох талаар:</b>										
Зорилт- 3.1. Зэвсэгт хүчнийг улс орны хэмжээний томоохон бүтээн байгуулалтад оролцуулах талаар санал боловсруулж, холбогдох төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэх чиглэлээр ажиллах	12.	Зэвсэгт хүчний удирдлагын төвийн шинэ байрыг барих төсвийг 2022 оны улсын төсөвт тусгуулах асуудлыг шийдвэрлүүлэх, барилгын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	2021-2023 онд	Хэрэгжилтийн хувь	Боловсруулагдсан барилгын зураг төсөл 10 хувь	Барилгын төсвийг 2022 оны улсын төсөвт суулгаж, барилгын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.	БХЯ	ЗХЖШ, БИЦУГ	СЯ	21,200.0 /улсын төсөв/
	13.	Барилга-инженерийн цэргийг улсыг хөгжүүлэх авто зам, төмөр зам, дэд бүтцийн ажилд оролцуулах талаар холбогдох яам, байгууллагатай хамтран ажиллах, санал боловсруулах	2021-2024 онд	Санал	Богдхан төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцуулах санал	БИЦ-ийг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах Засгийн газрын тогтоол гарна.	БХЯ	ЗХЖШ, БИЦУГ	БХБЯ, ЗТХЯ	Төсөв шаардахгүй
	14.	Барилга-инженерийн цэргийг улс орныг хөгжүүлэх стратегийн томоохон бүтээн байгуулалтын ажилд оролцуулах	2021-2024 онд	Бүтээн байгуулалтад оролцсон байдал	Авто зам, төмөр замын бүтээн байгуулалт	БИЦ бүтээн байгуулалтын ажилд оролцоно.	ЗХЖШ, БИЦУГ	БХЯ	БХБЯ, ЗТХЯ	Төслийн хөрөнгө
	15.	Барилга-инженерийн цэргийг хөгжүүлэх чиглэлээр гадаад оронтой хамтран ажиллах, бие бүрэлдэхүүнийг чадваржуулах чиглэлээр сургалт, дадлагыг зохион байгуулах	2021-2024 онд	Зохион байгуулсан сургалт дадлага, уулзалт	Япон Улсын Өөрийгөө батлан хамгаалах цэрэгтэй явуулсан "Зам-2021" сургалт	"Зам-2022" сургалт, дадлага явагдана.	ЗХЖШ, ХЗЦК, БИЦУГ	БХЯ	-	12,0 /улсын төсөв/

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Зорилт- 3.2. Зэвсэгт хүчнийг цөлжилт, байгалийн гамшигтай тэмцэх ажиллагаанд оролцуулах чадварыг бий болгох зорилгоор Зэвсэгт хүчний барилга, инженерийн цэргийн бүтцэд барилга-инженер экологийн анги салбаруудыг байгуулах асуудлыг анхааралдаа авч, төсөв хөрөнгийг батлуулан шийдвэрлүүлэх	16.	Барилга-инженер, экологийн ангийг байгуулах бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлж, барилгын ажлыг эхлүүлэх	2022-2024 онд	Хэрэгжилтийн хувь	Засгийн газрын тогтоолоор байгуулсан Барилга-инженерийн цэргийн анги 40 хувь	Барилга инженерийн цэргийн бүтээн байгуулалтын ажил эхэлнэ.	БИЦУГ	БХЯ	СЯ, ЗХЖШ	33,500.0 /улсын төсөв/
	17.	Зэвсэгт хүчнийг цөлжилт, байгалийн гамшигтай тэмцэх ажиллагаанд оролцуулах санал боловсруулах, энэ чиглэлээр гамшгаас хамгаалах болон бусад байгууллагатай хамтран ажиллах	2022 оны I улиралд	Санал, хамтран ажилласан байдал	Судлагдсан байдал 5 хувь	Санал гаргана, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.	БХЯ, ЗХЖШ	БИЦУГ, ОБЕГ	БОАЖЯ	Төсөв шаардахгүй
	18.	Барилга-инженер экологийн ангийг байгаль экологийн ажилд оролцуулах талаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, БОАЖЯ-тай хамтарсан тушаал гаргах	2022 оны II улиралд	Санамж бичиг	Хамтран ажиллах санамж бичгийн төсөл 5 хувь	Зөвлөлдөх уулзалт зохион байгуулагдаж, хамтарсан тушаал гарна.	БХЯ	БОАЖЯ, ЗХЖШ	БИЦУГ	Төсөв шаардахгүй
	19.	Байгаль экологи, ялангуяа цөлжилт, шороон шуургатай тэмцэх, гамшгаас хамгаалах ажилд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг оролцуулах	2022-2024 онд	Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний оролцоо	Судлагдсан байдал 5 хувь	Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн цөлжилттэй тэмцэх, гамшгаас хамгаалах ажилд оролцон, Зэвсэгт хүчний "Мод үржүүлгийн төв"-ийг байгуулж үйл ажиллагааг нь эхэлнэ.	ЗХЖШ, БИЦУГ	БОАЖЯ, ОБЕГ	БХЯ	Төслийн хөрөнгө, 100,0 (ЗХХС)

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
<b>Дөрөв. Тусгай хүчний болон Кибер аюулгүй байдлын цэргийг бэхжүүлэх, зэвсэглэл, техникийн шинэчлэлийг хэрэгжүүлэх талаар:</b>										
Зорилт – 4.1. Шинээр байгуулагдсан тусгай хүчний болон кибер аюулгүй байдлын командлалуудын чадавхыг бэхжүүлэх	20.	Кибер аюулгүй байдлын Дата төвийг байгуулах, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх ажлыг эхлүүлэх	2022 онд	Хэрэгжилтийн хувь	Шинэчлэл 10 хувь	30 хувь	КАБЦК	ЗХЖШ	БХЯ	6,800.0 /гадаадын тусламж/
	21.	Тусгай хүчний цэргийн удирдлагын байгууллагын бие даасан үйл ажиллагааг жигдрүүлэх, цэргийн техник, тусгай хэрэгслээр хангах	2021-2022 онд	Хэрэгжилтийн хувь	ТХЦК, тусгай хүчний анги байгуулсан 20 хувь	40 хувь	ТХЦК	ЗХЖШ	БХЯ	1,711.0 /гадаадын тусламж/
Зорилт - 4.2. Зэвсэг техникийн шинэчлэлийн ажлыг тууштай үргэлжлүүлж, цэргийн зориулалттай зарим бүтээгдэхүүнийг дотоодод үйлдвэрлэж байгаа сайн эхлэлийг Засгийн газрын түвшинд танилцуулан төсөв хөрөнгийн дэмжлэг авах замаар уг ажлыг эрчимжүүлэх	22.	Цэргийн зориулалттай техник, тоног төхөөрөмж үйлдвэрлэх Туршилт судалгааны төвүүдийг бэхжүүлэх хөрөнгө оруулалтын зардлыг Засгийн газраар шийдвэрлүүлэх	2022 онд	Шийдвэрлэгдсэн байдал	Туршилт судалгааны төвүүд байгуулагдана	Туршилт судалгааны төвүүдийг бэхжүүлэх хөрөнгө оруулалт хийгдэнэ.	БХЯ	ЗХЖШ	ТХЦК	1,290.0 /улсын төсөв/
	23.	Цэргийн зориулалттай автомашины үйлдвэрлэх туршилт судалгааны төвийг бэхжүүлэх, тусгай зориулалтын болон хуягласан автомашиныг дотооддоо үйлдвэрлэх	2021-2022 онд	Автомашин үйлдвэрлэсэн байдал	Туршилтаар 25 нэгж	10 нэгж үйлдвэрлэнэ.	ЗХЖШ	БХЯ	ТХЦК	500,0 /улсын төсөв/
	24.	“Нисгэгчгүй нисэх хэрэгслийн туршилт, судалгааны төв”-ийг бэхжүүлж, цэргийн тактикийн орон зайн судалгааны нисгэгчгүй нисэх хэрэгсэл бүтээх	2021-2022 онд	Цэргийн хэрэгт нэвтрүүлэх нисэх хэрэгслийн тоо	Нисэх хэрэгслийн тоо 2	2 нэгжийг зохион бүтээнэ.	АЦК	ЗХЖШ	БХЯ	150,0 /улсын төсөв/
	25.	Сумны үйлдвэр байгуулах хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх	2022 онд	Төслийн хэрэгжилтийн хувь	Судалгааны түвшин 20 хувь	Сумны үйлдвэртэй болох эхлэл тавигдана.	БХАҮН	БХЯ	ЗХЖШ	13,600 /улсын төсөв/

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	26.	РЭХ-ийн туршилт судалгааг хөгжүүлж, зарим тоног төхөөрөмж, техник хэрэгслийн үйлдвэрлэлийн технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх	2021-2022 онд	Бүтээсэн радио электрон хэрэгсэл	Эхний загвар хийгдсэн 20 хувь	5 загварыг бүтээнэ.	ЗХЖШ	БХЯ	-	250,0 /ЗХХС/
<b>Тав. Зэвсэгт хүчнийг Энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах талаар:</b>										
Зорилт – 5.1. НҮБ-ын ЭСА-нд цэргийн II шатны эмнэлэг, барилга инженерийн болон тусгай хүчний ангийг оролцуулах тооцоо, судалгаа хийж, бэлтгэлийг ханган оролцуулах	27.	НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд Тусгай хүчний ротын бэлтгэлийг хангаж, оролцуулах	2021-2024 онд	ЭСА-ны оролцоо	Бэлтгэж оролцуулах ажил 50 хувь	Тусгай хүчний рот ЭСА-нд оролцоно.	БХЯ	ЗХЖШ	ГХЯ	30,000.0 /улсын төсөв/
	28.	НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд Инженерийн ротын бэлтгэлийг хангаж, оролцуулах	2022-2024 онд	ЭСА-ны оролцоо	Засгийн газрын шийдвэр гарсан 20 хувь	Инженерийн рот ЭСА-нд оролцоно.	БХЯ	ЗХЖШ	ГХЯ	41,000.0 /улсын төсөв/
	29.	НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд Цэргийн II шатны эмнэлгийн бэлтгэлийг хангаж, оролцуулах	2022-2024 онд	ЭСА-ны оролцоо	Тооцоо, судалгаа 20 хувь	Цэргийн II шатны эмнэлэг ЭСА-нд оролцоно.	БХЯ	ЗХЖШ	ГХЯ	30,000.0 /улсын төсөв/
<b>Зургаа. Халхын голын ялалтын түүхт 85 жилийн ойг угтсан ажлыг зохион байгуулах талаар:</b>										
Зорилт – 6.1. Халхын голын ялалтын түүхт 85 жилийн ойг угтаж Халхын голын бүс нутагт байгаа түүхийн дурсгалт объект, барилга байгууламж, газрыг хамгаалах, сэргээн	30.	Халхын голын ялалтын түүхт 85 жилийн ой угтаж Халхын голын бүс нутагт байгаа түүхийн дурсгалт объект, барилга байгууламж, газрыг хамгаалах, сэргээн засварлах ажлыг зохион байгуулах	2022-2024 онд	Төслийн хэрэгжилтийн хувь	Хөшөө, дурсгалын судалгаа	Сэргээн засварлах нийт хөшөө, дурсгалын судалгааг гаргаж, сэргээн засварлана.	БХЯ, ЗХЖШ	БХЭШХ, Монгол цэргийн музей	ХХЕГ, Дорнод аймгийн ЗДТГ	Төслийн хөрөнгө
	31.	Цэргийн түүх, археологийн судалгааг хөгжүүлэх	2022 онд	Хэрэгжилтийн хувь	Бэлтгэл ажил 5 хувь	Мэдээллийн сан байгуулна. 30 хувь	БХЭШХ, Монгол цэргийн музей	БХЯ, ЗХЖШ	ХХЕГ, ШУА-ийн Археолог-ийн хүрээлэн	Төсөв шаардахгүй



1	2	3	4	5	6	7	8	9	10	11
засварлах ажлыг зохион байгуулах	32.	Халхын голын бүс нутагт цэргийн зориулалттай тэсэрч, дэлбэрэх зүйлсийг хайх, аюулгүй болгох	2022-2023 онд	Хэрэгжилтийн хувь	Тэсэрч, дэлбэрэх зүйлсийг хайх, аюулгүй болгох бүлэг томилно	Тэсэрч, дэлбэрэх зүйлсийг хайх, аюулгүй болгох ажлыг 2 үе шаттай явуулна.	ЗХЖШ	ХЗЦК, ТХЦК	БХЯ	Төслийн хөрөнгө
	33.	Халхын голын музейн үзмэр, өв санг баяжуулах, эх орончдын парк болгох ажлыг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2022 онд	Дэмжлэг үзүүлсэн байдал	Халхын голын музейн судалгаа	Халхын голын музейн үзмэр, өв санг баяжуулах ажил зохион байгуулагдсан байна.	БХЭШХ, Монгол цэргийн музей, БХТА	БХЯ	СЯ, ЗХЖШ, ХХЕГ	Төслийн хөрөнгө